



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/22

Улаанбаатар хот

Г Зочид буудал, дэн буудал, амралтын Г
газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
олгох, цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан 1 иргэн, аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан Цэлмүүн трейд ХХК "Дрийм" зочид буудлын 13/208, Иргэн Д.Гансүх "Стар" зочид буудлын 13/02 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

3. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага болон иргэн тус бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч /Г.Цэрэннадмид/-д даалгасугай.

4. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэд нь гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Отгонсүвд/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.БАТСҮХ



1150500086

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2017 оны 03 сарын 03
өдрийн А/22 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2017.03.03

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Цэлмүүн трейд ХХК	2695135	Дрийм	ЧД-ийн 4-р хороо 19-2
2	Иргэн Д.Гансүх	ХА75012761	Стар	БГД-ийн 12-р хороо 6-1

---ooOoo---